



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.06.05 № 117 УАГ-САГ/2013/СТА-ЗГСНТ

Зөрчил арилгуулах тухай

Засгийн газрын 2012 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- БНСУ-ын Эдийн засгийн хамтын ажиллагааны сангийн 5.3 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлээр "МОН-3 Төрийн холбооны суурь сүлжээг өргөтгөн шинэчлэх төсөл" 2001-2003 онд хэрэгжиж, төслийн хөрөнгийг төрийн өмчид бүртгэсэн боловч тухайн үед зээлийн гэрээ байгуулаагүй, Төрийн холбооны газар нь төсвөөс санхүүждэг байгууллага тул зээлийн хүү болон үндсэн төлбөрийг барагдуулах боломжгүйгээс одоо болтол тус газрын нэр дээр Засгийн газрын дотоодод дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлагаар бүртгэгдэж ирсэн, 2012 оны жилийн эцэст 9,046,290,578.00 төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна.

Уг зээлийн өрийг Монгол улсын Засгийн газар хариуцан төлөх тухай Сангийн яамны Төрийн сангийн газрын 2007 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн 5-76/1417 дугаар албан бичгээр ТӨХ болон Төрийн холбооны газарт мэдэгдэж байсан боловч холбогдох шийдвэрийг гаргаж шийдвэрлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19.1.4-д "... үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тогтоосон хугацаанд тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах" гэсэн заалтыг зөрчиж байна.

"Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан "Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1.1-д "...алдаа зөрчлийг арилгуулахаар төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд албан шаардлага өгнө" гэсэн заалтыг үндэслэн дараах Албан шаардлагыг өгч байна.

Дээр дурдсан үндэслэлээр төслийн зээлийн авлагын 9,046,290,578.00 төгрөгийг Засгийн газрын дотоодод дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлагаас хасаж, биелэлтийг 2013 оны 11 дүгээр сарын 15-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Төрийн сангийн газрын дарга Ч.Тавинжил, Санхүүгийн бодлого, өрийн удирдлагын газрын дарга Т.Доржханд нарт даалгав.

АХЛАХ АУДИТОР

Г.ЮРА

УХА0122